



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/170

Улаанбаатар хот

Заавар батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал” батлах тухай 91 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах зааврыг нэгдүгээр, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах зааврыг хоёрдугаар, цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах зааврыг гуравдугаар, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх зааврыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг удирдлагаар ханган, Боловсролын ерөнхий газар, аймаг нийслэлийн боловсролын газарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (О.Хуягцогт), Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ганбаатар нарт хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ч.Энх-Амгалан)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142210648

Боловсрол, шинжлэх ухааны
сайдын 2022 оны 05 дугаар сарын
12-ны өдрийн 11 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫГ ТӨЛӨВЛӨХ, ХУВААРИЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн хэсгийн “Сургалтын үйл ажиллагааны зардал”-ыг сургалтын байгууллагын түвшинд төлөвлөх, хуваарилахад энэхүү зааврыг баримтална.

1.2. “Сургалтын үйл ажиллагааны зардал”-ыг хэрэгжүүлэхэд Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын нэг, хоёр, гурав, дөрөвдүгээр хавсралтыг тус тус баримтална.

1.3. Энэ зааварт хэрэглэсэн “Сургалтын үйл ажиллагааны зардал /цаашид “хичээл, практикийн зардал” гэх/” гэж Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал”-ын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 3.3.2.2-д заасныг ойлгоно.

1.4. Хичээл, практикийн зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах цаас, шохой, бал, маркер/пломастер, принтер болон хувилагч машины хор, судлагдахууны онцлогтойгоор туршилт, дадлагын явцад ашиглах жижиг багаж хэрэгсэл, урвалж бодис, хэмжилт хийх багаж, лаа, зай, тугалган цаас, зүү, утас, даавуу, хадаас, мод материал, бэлдэц, хөгжмийн утас, хөгжмийн энгийн зэмсэг, бөмбөг, дасгал хөдөлгөөн хийхэд хэрэглэх жижиг хэрэгсэл гэх зэрэг, бага үнэтэй, түргэн элэгдэх хангамжийн материал, хэрэглэгдэхүүн худалдан авах зардал багтана.

Энэ зааврын 1.4-д заасан материалд суралцагчийн ялгаатай хэрэгцээнд үндэслэсэн сургалтын тохируулгат (харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан өнгө будаг тод, үсгийн хэмжээг тохируулсан бичмэл материал, брайл цаас, томруулдаг шил, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дохионы хэлний үзүүлэн, саажилттай хүүхдэд зориулсан тусгай үзэг бал гэх мэт) материал, хэрэглэгдэхүүн багтана.

1.5. Хичээл, практикийн зардлыг төлөвлөх, хуваарилах үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн, тэгш хүртээмжтэй, хамт олны оролцоонд үндэслэсэн, ил тод, нээлттэй байх зарчим баримтална.

Хоёр. Хичээл практикийн зардал төлөвлөх

2.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь тухайн санхүүгийн жилд зарцуулах хичээл практикийн нийт зардлыг “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын нэг, хоёрдугаар хавсралтаар баталсан “Хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”-ий “Суурь хувьсах зардлын бүрэлдэхүүн” дэх “Сургалтын үйл

ажиллагааны зардал"-д ногдох хэмжээ буюу цэцэрлэг нийт хувьсах зардлын¹ 1.2 хувь, ерөнхий боловсролын сургууль 1.5 хувь байхаар тус тус тооцон дор дурдсан томъёогоор (1), (2) тооцон гаргана:

$$N_k = ((S - S_1) * M_k + (S_1 * 3M_k)) * t * 0.012 \quad (1)$$

$$N_{Sc} = N_{pr} + N_{sec} + N_h \quad (2)$$

$$(a) N_{pr} = ((S_{pr} - S_{1pr}) * M_{pr} + (S_{1pr} * 3M_{pr})) * t * 0.015,$$

$$(б) N_{sec} = ((S_{sec} - S_{1sec}) * M_{sec} + (S_{1sec} * 3M_{sec})) * t * 0.015$$

$$(в) N_h = ((S_h - S_{1h}) * M_h + (S_{1h} * 3M_h)) * t * 0.015$$

N_k-тухайн цэцэрлэгийн хичээл практикийн нийт зардал

N_{Sc}-тухайн ЕБС-ийн хичээл, практикийн нийт зардал, N_{pr}-бага ангийн, N_{sec}-дунд ангийн, N_h-ахлах ангийн сурагчдын хичээл, практикийн нийт зардал

M_k-нэг хүүхдэд ногдох хувьсах зардал

M_{Sc}-нэг хүүхдэд ногдох хувьсах зардал

S-цэцэрлэг/ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн тоо

S¹-цэцэрлэг/ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

t-тухайн сургалтын байгууллагад хамаарах хувьсах зардал тооцох итгэлцүүр (тухайн сургалтын байгууллагад хамаарах бүх итгэлцүүрийн үржвэр)²

2.2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөнд үндэслэн энэ зааврын 2.1-д заасны дагуу тооцож гаргасан хичээл практикийн нийт зардалд багтаан анги, хичээл бүрийн хичээл, практикийн зардлын нэгжийг тооцоолж (3) гаргана.

$$E_{Sc} = \frac{N_{Sc}}{Q_{Sc}} \quad (3) \quad Q_{Sc} = \sum_{i=1}^{12} (k_i * l_i)$$

E_{Sc}-хичээл практикийн зардлын нэгж, Q_{Sc}-сургалтын төлөвлөгөөгөөр тухайн хугацаанд судлах нийт цагийн тоо, i-ангийн дугаар, k_i- i-р ангид сургалтын төлөвлөгөөгөөр судлах нийт цаг, l_i-тухайн сургуулийн i-р ангийн бүлгийн тоо.

2.3. Ерөнхий боловсролын сургуулийн багш бүрийн 7 хоногт заах цагт үндэслэн хагас болон бүтэн жилд заах хичээлийн цагийг энэ зааврын 2.2-д заасан нэгж зардал *E_{Sc}*-аар үржүүлж тухайн хугацаанд ашиглах хичээл, практикийн зардлын хэмжээг тооцно. Жишээ нь: *А багш хагас жил (9-12 дугаар сар)-д 326 цагийн хичээл заах тохиолдолд хичээл практикийн зардлыг N_A = 326 * E_{Sc} гэж тооцно.*

2.4. Цэцэрлэгийн хичээл практикийн нийт зардлыг нийт үндсэн багш (*бүлгийн болон хөгжим, биеийн тамирын багшийн нийт тоо*) тоонд хувааж тухайн хугацаанд ашиглах хичээл, практикийн зардлын нэгж (4)-ийг тооцно.

$$E_k = \frac{N_k}{Q_k} \quad (4) \quad Q_k - \text{тухайн цэцэрлэгийн нийт багш-бүлгийн тоо}$$

2.5. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нийт багшийн хэрэглэх хичээл, практикийн зардлын дээд хэмжээ нь *N_k, N_{Sc}* -ээс хэтрэхгүй байна.

¹ Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар баталсан "Хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн" дэх суурь (А) + бусад (Б) хувьсах зардлын нийлбэрийг нийт хувьсах зардалд ойлгоно.

² Ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад ногдох хувьсах зардлыг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 4.1.4-д заасны дагуу гурав дахин нэмэгдүүлж тооцно.

Хичээл практикийн зардал /ХПЗ/ тооцох тооцооллын жишээ:

Ерөнхий боловсролын сургууль:

Сумын төвд байршилтай ердийн хэв шинж бүхий G дугаар сургууль 1,231 суралцагчтай сургууль. Тус сургуулийн бүлэг, бага, дунд, ахлах ангийн сурагчдын тоог дараах Хүснэгтэд харуулав.

	Бүгд	Анги/бүлгийн тоо											
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Сургалтын төлөвлөгөөгөөр судлах нийт цаг	11,499	666	704	704	768	864	957	1115	1115	1115	1115	1188	1188
Бүлэг	28	3	3	2	2	2	3	2	2	2	3	2	2
Суралцагч	1231	512					465					254	
Үүнээс: хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	25	12					8					5	

Энэ нөхцөлд G дугаар сургуулийн нэг хичээлийн жилд хэрэглэх хичээл практикийн нийт зардал ($N_{Sc} = N_{pr} + N_{sec} + N_h$) хичээлийн жил болон хагас жил /9-12 сар буюу 16 долоо хоног/-ээр тооцон гаргавал:

$$N_{pr} = ((512 - 12) * 910.0 + (12 * 3 * 910.0)) * 1.08 * 1.22 * 0.015 = 9,640.0 \text{ /мян.төг/}$$

$$N_{sec} = ((465 - 8) * 950.0 + (8 * 3 * 950.0)) * 1.08 * 1.22 * 0.015 = 9,031.1 \text{ /мян.төг/}$$

$$N_h = ((254 - 5) * 910.0 + (5 * 3 * 910.0)) * 1.08 * 1.22 * 0.015 = 4,748.1 \text{ /мян.төг/}$$

(Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан итгэлцүүр: 1.08-байршил, 1.22-суралцагчийн тооноос хамаарах итгэлцүүр, 0.015-2 дугаар хавсралтаар баталсан нийт хувьсах зардлаас ХПЗ-д ногдох 1.5 хувь)

$$N_{Sc} = N_{pr} + N_{sec} + N_h = 9,640.0 + 9,031.1 + 4,748.1 = 23,419.3 \text{ /мян.төг/}$$

Сургалтын төлөвлөгөөнд үндэслэн тус сургуулийн ХПЗ-ын нэгж /энэхүү нэгж нь хүүхэд, бүлгийн тооноос хамаарч жил бүр өөрчлөгдөнө/-ийг тооцвол:

$$E_g = \frac{N_{Sc}}{Q_{Sc}} = \frac{23,419,352}{26440} = 885.7 \text{ төг /ХПЗ-ын нэгж/}$$

$$Q_{Sc} = \sum_{i=1}^{12} (k_i * l_i) = 3 * 666 + 3 * 704 + 2 * 704 + 2 * 768 + 2 * 864 + 3 * 957 + 2 * 1115 + 2 * 1115 + 2 * 1115 + 3 * 1115 + 2 * 1188 + 2 * 1188 = 26440 \text{ цаг}$$

*Дээрх тооцоог хийхэд сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан багш зохицуулах цагийг тооцоогүй.

Нэг багшид ногдох хичээл практикийн зардлыг жишээгээр харуулбал:

Жишээ 1: Бага ангийн багш В нь 3 дугаар ангид хичээл заадаг. Тус ангийн нэг бүлэгт сургалтын төлөвлөгөөгөөр жилд 704 цагийн хичээл тусгагдсан бөгөөд хөгжим, биеийн тамирын хичээлийн мэргэжлийн багш заана гэж тооцвол В багш жилд нийт 576 цагийн хичээл заах төлөвлөгөөтэй. Иймд В багшийн тухайн хичээлийн жил /32 долоо хоног/-д хэрэглэх нийт ХПЗ нь $V_{ХПЗ} = 576 * 885.7 = 510,194$ төгрөг байна. Энэхүү зардлыг хичээллэх 7 хоногийн тооноос хамааруулан хагас жилээр тооцон төлөвлөнө. Багш хичээлийн жилийн эхний хагас жил буюу 16 долоо хоногт 255,097 төгрөгийн ХПЗ ногдоно.

Жишээ 2: Математикийн багш С нь сургалтын төлөвлөгөөний дагуу 7 хоногт 24 /дунд, ахлах ангийн математикийн хичээл 7 хоногт 4 цаг байдаг тул багш ихэвчлэн 20, 24 цаг заах тохиолдол түгээмэл байдаг/ цаг, хичээлийн жил /34 долоо хоног/-д нийт 816 цагийн хичээл заах төлөвлөгөөтэй. С багшийн тухайн хичээлийн жилд хэрэглэх нийт ХПЗ нь $C_{ХПЗ} = 816 * 885.7 = 722,731$ төгрөг байна.

Энэхүү зардлыг хичээллэх 7 хоногийн тооноос хамааруулан хагас жилээр тооцон төлөвлөнө. С багш хичээлийн жилийн эхний хагас жил буюу 16 долоо хоногт 361,365 төгрөгийн ХПЗ ногдоно.

Дээрх жишээ 1, жишээ 2-оос харахад ХПЗ тооцох нэгж нь ээлжит хичээл /40 минутын хичээл/-д зарцуулах зардал байх тул багшийн 7 хоногт заах нийт цагаас хамаарч өөрчлөгдөнө.

Цэцэрлэг:

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг ердийн хэв шинж бүхий Q цэцэрлэг нь 156 хүүхэд, 5 бүлэгтэй. Нийт 6 үндсэн багш (бүлгийн багш 5, хөгжмийн багш 1) ажилладаг бөгөөд тус цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй 7 хүүхэд хамрагддаг.

Энэ нөхцөлд Q цэцэрлэгийн нэг хичээлийн жилд хэрэглэх хичээл практикийн нийт зардал ($N_k = ((S - S_1) * M_k + S_1 * 3M_k) * t * 0.012$) хичээлийн жилээр тооцон гаргавал:

$$N_k = ((156 - 7) * 1020.0 + (7 * 3 * 1020.0)) * 1.065 * 1.42 * 0.012 = 3,146.8 \text{ /мян.төг/}$$

(Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан итгэлцүүр: 1.065-байршил, 1.42-

суралцагчийн тооноос хамаарах итгэлцүүр, 0.012-ийг хувьсах зардлаас ХП-т ногдох 1.2 хувь)

Цэцэрлэгийн хичээл практикийн зардлын нэгж /хичээлийн жилд 1 багш/бүлэгт ногдох ХПЗ/-ийг тооцвол:

$$E_q = \frac{3,146,794}{6} = 524.466 \text{ төг}$$

2.6. Хичээл практикийн зардлыг дор дурдсан зориулалтад заасан хувь хэмжээг баримтлан зарцуулахаар тооцож төлөвлөлт хийнэ.

Зориулалт	Цэцэрлэг	Ерөнхий боловсролын сургууль
Сургалтын хэрэглэгдэхүүн (бичгийн хэрэгсэл, биет болон зурагт үзүүлэн, тараах материал хийх бэлдэц)	65-70 хувь	-
Цахим хэрэглэгдэхүүн (видео, аудио хэрэглэгдэхүүн, хөдөлгөөнт файл зэрэг) бэлтгэх, хэрэглэх	25 хувь	-
Ялгаатай хэрэгцээтэй суралцагчид шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүн	5<хувь	5<хувь
Бичгийн хэрэгсэл	-	40 хүртэл хувь
Судлагдахууны онцлогоос хамаарсан хичээлийн болон лабораторийн жижиг багаж, хэрэгсэл	-	50-55 хувь

2.7. Хичээл практикийн зардлыг тухайн санхүүгийн жилд 2 удаа (тухайн оны 1 болон 8 дугаар сар) олгохоор тооцно.

2.8. Багш бүр хичээл, сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтдөө үндэслэн шаардлагатай материал, хэрэглэгдэхүүний жагсаалтыг гаргаж, заах аргын нэгдэл, секцээр хэлэлцэн хагас жил/жилийн хугацаанд хэрэглэх материал, хэрэглэгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг энэ зааврын 2.6-д заасан хувь хэмжээнд нийцүүлэн тодорхойлж, цэцэрлэгийн арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерт заах аргын нэгдлийн ахлагч танилцуулна.

2.9. Энэ зааврын 2.8-д заасан арга зүйч, сургалтын менежер нь багшийн төлөөлөлтэй хамтран заах аргын нэгдэл, секцийн саналыг хянаж, нэгтгэн хагас жил тутамд хичээл, сургалтын үйл ажиллагаанд хэрэглэх материал, хэрэглэгдэхүүний жагсаалт, тэдгээрийг нийлүүлэх төлөвлөгөөний төслийг мэргэжлийн чиглэл, багш бүрээр гаргаж, багш нарын зөвлөлийн хуралд нээлттэй танилцуулна.

2.10. Энэ зааврын 2.9-д заасан төлөвлөгөөний төсөлд багш нарын зөвлөлийн хурлаас гарсан саналыг тусгаж, төлөвлөгөөг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал тус тус баталж, мөрдөнө.

Гурав. Сургалтын үйл ажиллагаанд ашиглах материал, хэрэглэгдэхүүний хуваарь, тэдгээрийн хангамж

3.1.Цэцэрлэгийн арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер нь заах аргын нэгдэл болон секцийн ахлагч, байгууллагын нягтлан бодогчтой хамтран энэ зааврын 2.10-т заасан төлөвлөгөөнд үндэслэн “Сургалтад ашиглах материал, хэрэглэгдэхүүний хангамжийн хуваарь” гаргана.

3.2.“Хангамжийн хуваарь”-т тухайн жилийн хагас жилд багш бүрийн ашиглах материал, хэрэглэгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, нийлүүлэх хугацаа багтсан байх бөгөөд хуваарийг багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал тус тус баталгаажуулна.

3.3. Энэ зааврын 3.2-т заасан хуваарийн дагуу сургалтад ашиглах материал, хэрэглэгдэхүүнийг сонгох, худалдан авах, заах аргын нэгдэл/секцийн ахлагчид хүлээлгэн өгөх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлын тушаалаар тус тус томилон ажиллуулна.

3.3.1. Ажлын хэсэгт цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, нярав, болон эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл багтах бөгөөд ажлын хэсэг энэ зааврын 3.3-т заасан үйл ажиллагааг тухайн санхүүгийн жилд 2 удаа зохион байгуулна.

3.3.2. Хичээл, сургалтын үйл ажиллагаанд ашиглах материал, хэрэглэгдэхүүнийг сонгох, худалдан авах, заах аргын нэгдэл/секцийн ахлагчид хүлээлгэн өгөх үйл ажиллагааны тайланг ажлын хэсэг тухай бүр хамт олны хуралд танилцуулна.

3.4. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд заах аргын нэгдлийн ахлагч нар болон байгууллагын дотоод хяналт хариуцсан ажилтан тус тус хяналт тавина.

Дөрөв. Бусад

4.1. Хичээл, сургалтын үйл ажиллагаанд ашиглахаар нийлүүлсэн материал, хэрэглэгдэхүүнийг багш зориулалтын дагуу үр өгөөжтэй ашиглах бөгөөд ашиглалтад цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн сургалтын менежер, заах аргын нэгдэл болон секцийн ахлагч тус тус хяналт тавьж, мэргэжил-арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

4.2. Хичээл, практикийн зардлаар нийлүүлсэн олон удаа ашиглах боломжтой хичээлийн болон лабораторийн жижиг багаж, хэрэгсэл /бөмбөг, дээс, пломастер, гортиг, шугам бусад хэмжилтийн багаж, туршилтад ашиглах материал гэх мэт/-ийг кабинет, анги танхимд тус тус байршуулж, суралцагчдад чөлөөтэй ашиглуулна.

4.3. Хичээл, практикийн зардлаас санхүүжүүлж нийлүүлсэн материал, хэрэглэгдэхүүнийг үндсэн хөрөнгөд бүртгэхгүй.

4.4. Хичээл, практикийн зардлаас санхүүжүүлж нийлүүлсэн сургалтад ашиглах материал, хэрэглэгдэхүүнийг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС)-ын бараа материалын стандартыг үндэслэн шууд зардалд бичиж тайлагнана.

Боловсрол, шинжлэх ухааны
сайдын 2022 оны 05 дугаар сарын
12-ны өдрийн 14 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт.



**БАГШИЙН ТАСРАЛТГҮЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ,
ТҮҮНИЙГ ЗАРЦУУЛАХ ЗААВАР**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар баталсан "Хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн" хэсэгт заасан "Багшийн хөгжлийн зардал"-ыг төлөвлөх зарцуулах, тайлагнах, хяналт тавихад энэхүү зааврыг баримтална.

1.2. Энэ зааврын 1.1-д хэрэглэсэн "Багшийн хөгжлийн зардал" гэж Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 3.4.3 дахь заалт, мөн аргачлалын "Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар"-ын 3-т заасныг тус тус ойлгоно.

1.3. Багшийн хөгжлийн зардлыг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль /цаашид "сургалтын байгууллага" гэх/-ийн багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих, ур чадварыг сайжруулах сургалт, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна.

1.4. Багшийн хөгжлийн зардал нь Засгийн газрын 2022 оны "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай" 91 дүгээр тогтоолын 1,2 дугаар хавсралтад заасан хэмжээ буюу цэцэрлэгт нийт хувьсах зардлын 0.6 хувь, ерөнхий боловсролын сургуульд нийт хувьсах зардлын 0.9 хүртэл хувь байна.

1.5. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний дүн, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх хэрэгцээг тус тус харгалзан дунд хугацаанд баримтлах "Багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө", тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус батлан хэрэгжүүлнэ.

1.5.1. Энэ зааврын 1.5-д заасан тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жилийн бүрийн 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Боловсролын ерөнхий газрын "Багшийн хөгжил" сургалтын платформ /цаашид "платформ" гэх/-д байршуулах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах ажлыг цэцэрлэгийн арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер тус тус хариуцна.

1.6. Платформд байршуулсан төлөвлөгөөний хэрэгжилтэд нийслэлийн боловсролын газар, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

1.7. Сургалтын байгууллага нь багшийн хөгжлийг дэмжих зардлыг тухайн хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээлэлд үндэслэн энэ аргачлалын 1.4-д заасан хувь хэмжээгээр тооцож, тухайн жилд зарцуулах нийт төсвийг төлөвлөнө.

1.8. Багшийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг дараах чиглэлээр зохион байгуулна.

- 1.8.1. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургалт;
- 1.8.2. Багшийн хөгжлийг дэмжих бусад үйл ажиллагаа.

1.9. Тухайн жилд батлагдсан “Багшийн хөгжлийн зардал”-ын төсвийн 60 хүртэлх хувийг энэ зааврын 1.8.1-д заасан сургалтад, 40 хүртэлх хувийг зааврын 1.8.2-т заасан бусад үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна.

1.10. “Багшийн хөгжлийн зардал” хэмнэгдсэн тохиолдолд 1.8.1 болон 1.8.2-т заасан сургалт, үйл ажиллагаанд шилжүүлэн зарцуулж болно.

Хоёр. Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургалт

2.1. Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургалт нь дараах төрөлтэй байна.

- 2.1.1. үндсэн сургалт
- 2.1.2. зорилтот сургалт
- 2.1.3. сонголтот сургалт

2.2. Энэ зааврын 2.1.1-д заасан сургалт нь Боловсролын тухай хуульд заасан 5 жил тутам багшийн мэргэжлийг дээшлүүлэх сургалт байна.

2.3. Энэ зааврын 2.1.2, 2.1.3-т заасан сургалт нь “Багшийн хөгжлийн зардал”-аас санхүүжих, нийт 3 багц цагаар хэмжигдэх модуль сургалт байна.

2.4. Энэ зааврын 1.8.1-д заасан сургалтад зорилтот болон сонголтот сургалт хамаарах бөгөөд сургалтыг цахим платформ түшиглэн зохион байгуулна.

2.5. Зорилтот сургалт нь 1-2 багц цагийн модуль сургалт байна.

2.5.1. Багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээнд үндэслэн багшийн мэргэжлийн хөгжил, ур чадварыг дээшлүүлэх хэрэгцээг багш, сургалтын байгууллага, орон нутаг болон үндэсний түвшинд тус тус тодорхойлж, энэ аргачлалын 2.5.1.1, 2.5.1.2-т заасан зорилтот сургалт зохион байгуулна.

2.5.1.1. ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээгээр тухайн багшийн заадаг хичээлээр суралцагчийн сурлагын амжилт “хангалтгүй” үнэлэгдсэн агуулга (суралцахуйн зорилт)-ын хүрээнд багшийн онолын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх “Заавал судлах” сургалт;

2.5.1.2. сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад багшид тулгамдаж байгаа онолын мэдлэгийг дээшлүүлэх, заах арга зүй, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшлийн хөгжлийг дэмжих “Сонгон суралцах” сургалт.

2.6. Сонголтот сургалт нь багш, ажилтны мэргэжлийн тусгай ур чадвар, хувь хүний хөгжилд дэмжлэг үзүүлэх нэг багц цагийн модуль сургалт байна.

2.7. Энэ аргачлалын 2.5, 2.6-д заасан сургалтад багш, ажилтан дараах зохион байгуулалтаар хамрагдана.

2.7.1. багш нь ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээ болон өөрийн мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх хэрэгцээнд үндэслэн (жилд 2 удаа) цэцэрлэгийн арга зүйч/сургуулийн холбогдох сургалтын менежертэй зөвшилцөн Боловсролын ерөнхий газраас зарласан “заавал” болон “сонгон” судлах модуль сургалтад хамрагдана.

2.7.2. заадаг хичээлээр суралцагчид нь “хангалтгүй” үнэлэгдсэн тохиолдолд энэ зааврын 2.7.1-д заасан заавал судлах модуль сургалтад тухайн багшийг хамруулна.

2.7.3. багшийн сонгосон модулийг сургалтын байгууллагын түвшинд нэгтгэх, энэ аргачлалын 1.5-д заасан төлөвлөгөөг заах аргын нэгдэл, мэргэжил бүлгийн оролцоотой боловсруулах, зааврын 1.5.1-д заасан платформд сургалтын

захиалга өгөх ажлыг цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн сургалтын менежер тус тус хариуцна.

2.7.4. сургалтын байгууллага нь багш нарын сонгосон модулийн бүртгэл энэ зааврын 1.5.1-д заасан платформд баталгаажсаны дараа сургалтын төлбөрийг Боловсролын ерөнхий газрын холбогдох дансанд шилжүүлнэ.

Гурав. Багшийн хөгжлийг дэмжих бусад үйл ажиллагаа

3.1. Багшийн хөгжлийг дэмжих бусад үйл ажиллагаа нь ажлын байранд багш, ажилтны хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

3.2. Багшийн хөгжлийг дэмжих бусад үйл ажиллагаа нь сургалтын байгууллага, багш эсхүл сургалтын байгууллага хооронд хамтран ажиллах, онол-практикийн хурал, семинар, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, туршлага солилцох уулзалт, мэргэжлийн сэтгүүлд арга туршлагаасаа хэвлүүлэх болон багш солилцооны хөтөлбөрт хамруулах зэрэг хэлбэрээр зохион байгуулагдана.

3.3. Цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн сургалтын менежер нь багшийн хөгжлийг дэмжих бусад үйл ажиллагааны талаарх саналыг багш, ажилтан, заах аргын нэгдэл, секц, мэргэжлийн хөгжлийн бүлгээс тус тус авч энэ зааврын 1.5-д заасан төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлнэ.

Дөрөв. Бүртгэл, мэдээлэл, тайлагнал

4.1. Боловсролын ерөнхий газар, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газар, цэцэрлэг, сургууль нь платформд багш ажилтны модуль сургалтын батламж, гэрчилгээ болон хөгжлийг дэмжих бусад үйл ажиллагаанд оролцсон мэдээллийг тухай бүр бүртгэж баталгаажуулсан байна.

4.2. Платформд бүртгэгдсэн мэдээлэл нь багш, ажилтны ажлыг үнэлэх, урамшуулал олгох үндэслэл болно. Хэрэв хүндэтгэх шалтгаанаар сургалтад хамрагдаж чадаагүй бол сургалтын байгууллагатай зөвшилцөн дараагийн хэрэгцээт сургалтад хамрагдаж болно. Багш, ажилтан өөрийн буруугаас сургалтад хамрагдаагүй бол төлбөрийг хувиасаа төлж, сургалтад заавал хамрагдана.

4.2.1 Сургалтын байгууллага нь багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг платформд бүртгэх, баталгаажуулах, гүйцэтгэлд хяналт тавих, төлбөрийг шилжүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах ажлыг зохион байгуулна.

4.3. Орон нутгийн түвшинд аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газар зардлын зарцуулалт, гүйцэтгэлд хяналт тавин, үнэлгээ хийж, тайланг хагас бүтэн жилээр Боловсролын ерөнхий газрын платформд байршуулна.

Тав. Бусад

5.1. Энэ зааврын 2.2-т заасан сургалттай холбогдох зардал “Багшийн хөгжлийн зардал”-д хамаарахгүй.

5.2. Багшийн хөгжлийг дэмжих зардлаас дараах арга хэмжээг санхүүжүүлэхгүй

5.2.1. бакалавр, магистр, докторын сургалтын төлбөр төлөх;

5.2.2. туршлага судлах зорилготой дотоод болон гадаадад аялал зохион байгуулах;

5.2.3. аливаа олимпиад, уралдаан тэмцээнд оролцох зардал.

5.3. Энэ зааврын 2.3,2.5-д заасан модуль сургалтад бүртгүүлж, баталгаажилт хийгдсэний дараа хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сургалтад хамрагдаагүй тохиолдолд тухайн багш Боловсролын ерөнхий газарт хүсэлт гарган сургалтад нөхөн хамрагдана.

5.4 Хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд бүртгүүлсэн сургалтад хугацаандаа хамрагдаагүй багш сургалтад заавал хамрагдах бөгөөд сургалтын зардлыг өөрөө хариуцна.

5.5. Энэ зааврын 2-т заасан холбогдох сургалтад багш хамрагдаж буй эсэхэд цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн сургалтын менежер хяналт тавина.

---000---

Боловсрол, шинжлэх ухааны
сайдын 2022 оны 05 дугаар сарын
12-ны өдрийн А/1.70 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЦАХИМ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДЛЫГ ТӨЛӨВЛӨХ, ХУВААРИЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн хэсгийн "Цахим хэрэглээний зардал"-ыг төлөвлөх, хуваарилахад энэхүү зааврыг баримтална.

1.2. "Цахим хэрэглээний зардал"-ыг хэрэгжүүлэхэд Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын хавсралтыг тус тус баримтална.

1.3. Энэ зааварт хэрэглэсэн "Цахим хэрэглээний зардал" гэж Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын "Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар"-ын 5-д заасныг ойлгоно.

1.4. Цахим хэрэглээний зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай дата, цахим систем, цахим эрх зэрэг бусад мэдээлэл технологийн ашиглалтын зардал багтана.

1.5. Цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн, тэгш хүртээмжтэй, хамт олны оролцоонд үндэслэсэн, ил тод, нээлттэй байх зарчим баримтална.

Хоёр. Цахим хэрэглээний зардал төлөвлөх

2.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь тухайн санхүүгийн жилд зарцуулах Цахим хэрэглээний нийт зардлыг "Хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн"-ий "Бусад хувьсах зардлын бүрэлдэхүүн"-ий "Цахим хэрэглээний зардал"-д ногдох хэмжээ буюу цэцэрлэг нийт хувьсах зардлын 0.4 хувь, ерөнхий боловсролын сургууль 1.0 хувь байхаар тус тус тооцно.

2.2. Цахим хэрэглээний зардлыг дата, цахим систем, цахим эрх гэсэн сонголттойгоор төлөвлөн зарцуулах боломжтой юм.

2.3 Энэ зааврын 2.2-т хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно.

2.3.1 Дата гэдэг нь үүрэн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас хангадаг интернэт холболт юм. Энд Wi-Fi төхөөрөмжөөр интернэт холболт үүсгэхийг тооцохгүй.

2.3.2 "Цахим систем" гэж тоон хэлбэрт буй мэдээллийг хадгалах, боловсруулах, дамжуулах зорилгоор бүтээгдсэн сургалтын үйл ажиллагаанд ашиглагдах (суралцахуйн удирдлагын систем) программ хангамжийг хэлнэ. Цахим систем гэдэгт суралцахуйн удирдлагын гэх мэт сургалтын үйл ажиллагаанд ашиглах системүүдийг тус тус ойлгоно.

2.3.3 "Цахим эрх" гэж цахим хэлбэрт буй бичвэр, зураг, бичлэг эсвэл энэ бүгдийг багтаасан агуулга эсвэл цахим систем ашиглах эрхийг хэлнэ. Сургалтад ашиглах зорилгоор цахим агуулгыг эрхийн дагуу татах, систем нэвтэрч ашиглахыг ойлгоно. Жишээ нь: Camtasia-ийн эрх гэх мэт шаардлагатай программ хангамжийн лицензийг худалдаж авч болно.

2.4. Дата багцыг сонгосон нөхцөлд цахим хэрэглээний нийт зардлыг нийт үндсэн багш (бүлгийн болон хөгжим, биеийн тамирын багшийн нийт тоо) тоонд хувааж тухайн хугацаанд ашиглах цахим хэрэглээний зардлын нэгж (1)-ийг тооцно.

$$E_k = \frac{N_k}{t * Q_t} (1)$$

Q_t-тухайн байгууллагын үндсэн багшийн тоо
t – цахим хэрэглээг ашиглах хугацаа /сараар/

2.5. Цахим системийн зардлыг байгууллагын болон суралцахуйн үйл ажиллагаатай уялдуулан цахим хэрэглээний төсөвт багтаан төлөвлөнө.

2.6. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг нь суралцахуйн болон сургалтын байгууллагын удирдлагын системд тавих шаардлагад нийцсэн цахим системийг сонгон хэрэглэнэ.

2.7. Цахим эрхийг сургалтын үйл ажиллагаатай уялдуулан судлагдахуун болон уг эрхийг хэрэглэх хэрэглэгчийн тоотой уялдуулан зардлыг төлөвлөнө.

2.8. Цахим хэрэглээний зардлыг үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хийсэн гэрээний заалт болон улирал (хичээлийн жил)-аар уян хатан олгохоор тооцно.

Гурав. Цахим хэрэглээний багцыг сонгох, захиалах, зарцуулах

3.1. Тухайн байгууллага нь багш, удирдах ажилтны төлөөллөөс бүрдсэн сайн дурын цахим хэрэглээний төсөв, түүний төлөвлөлт, захиалга, хэрэгжилтийг зохион байгуулах баг /цаашид хэрэгжилтийн баг гэх/, түүнд тавих хяналт, шинжилгээний баг /цаашид хяналтын баг гэх/-ийг тус тус байгуулна.

3.2 Зааврын 3.1-д заасан баг нь хичээлийн жилийн турш үйл ажиллагааг зохион байгуулна.

3.3 Хэрэгжилтийн баг нь цахим хэрэглээний нийт төсвийг тооцон нийт багш нарт танилцуулна.

3.4. Багш нь 3.1-д үндэслэн цахим хэрэглээний сонголтыг сургалтын үйл ажиллагаатай уялдуулан өөрөө сонгоно.

3.5. Багшийн сонголтуудыг нэгтгэн хэрэгжилтийн баг сургуулийн хэмжээний судалгааг гарган байгууллагын багш, ажилтанд цахим хэрэглээний хувилбарыг танилцуулан хурлаар сонголтыг баталгаажуулж, тус сонголтын хүрээнд цахим хэрэглээний жилийн төлөвлөгөөг гаргаж, захиалгыг хийнэ.

3.6. Хяналтын баг нь сар бүр дата багц сонгосон багш, ажилтны хэрэглээний тайланг үүрэн холбооны оператор компаниудаас гаргуулан авч, үр дүнд шинжилгээ хийн дүгнэлтийг багш нарын зөвлөлийн хуралд улирал (хичээлийн жил) бүр нээлттэй танилцуулна.

3.7. Цахим эрх, цахим системийн хувьд багш, ажилтанаас ашиглалтын талаар илтгэх хуудсыг сар бүр бичүүлж, үр дүнд шинжилгээ хийн дүгнэлтийг багш нарын зөвлөлийн хуралд улирал (хичээлийн жил) бүр нээлттэй танилцуулна.

3.8. Цахим хэрэглээний нээлттэй танилцуулгаас дараагийн сонголтыг хийх шийдвэрийг тухай бүрд гаргаж, төлөвлөгөөг шинэчлэн хэрэгжүүлж болно.

Боловсрол, шинжлэх ухааны
сайдын 2022 оны 05 дугаар сарын
12-ны өдрийн А/190 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН
СУРГАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ НӨХӨН
ХАНГАЛТЫН ЗАРДЛЫГ ТӨЛӨВЛӨХ, ХУВААРИЛАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЗААВАР,
АРГАЧЛАЛ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай суурин болон зөөврийн компьютер, цахим хэрэглэгдэхүүн, байгалийн ухааны лаборатори, биет үзүүлэн болон сургалтын хэрэглэгдэхүүн г.м тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүнийг сургуулийн биет орчны батлагдсан стандартад нийцүүлэн бүрдүүлэх, сургалтын хэвийн үйл ажиллагаанд ашиглах, эзэмших, үе шаттай шинэчлэх, сайжруулах харилцааг зохицуулахад энэхүү заавар, аргачлалын зорилго оршино.

1.2 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн хэсгийн “сургалтын тоног, төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал”-ыг төлөвлөх, хуваарилахад энэхүү зааврыг баримтална.

1.3 “Сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт”-ыг хэрэгжүүлэхэд Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын “хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 9 дэх хэсгийг баримтална.

1.4 Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэг болон төрийн өмчийн шинээр ашиглалтад орж буй сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмжийн хангалтын асуудал хамаарахгүй.

**ХОЁР. СУРГАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН НӨХӨН ХАНГАЛТАД
БАРИМТЛАХ ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ**

2.1. Сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

2.1.1. Хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх, багшийн хичээл заахад шаардлагатай тоног төхөөрөмжийн хэрэгцээг хангах;

2.1.2. Сургалтын байгууллага өөрийн удирдлага буюу эцэг эхийн зөвлөлийн оролцоог хангаж, бие даан шийдвэр гаргах;

2.1.3. Төлөвлөх, шийдвэр гаргах, тайлагнах үйл ажиллагаа ил тод байх;

2.1.4. Тоног төхөөрөмжийн хэрэгцээг ач холбогдлоор эрэмбэлж, жил бүр үе шаттай шийдвэрлэдэг байх.

2.2. Сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах алхмыг мөрдөнө.

2.2.1. Боловсролын систем дэх сургалтын хэрэглэгдэхүүний өнөөгийн төлөв байдлын судалгаа хийж (тоон болон чанарын үзүүлэлт, хүртээмж), тулгамдсан хэрэгцээг ач холбогдлоор эрэмбэлж тодорхойлж, нэн шаардлагатай 3-4 төрлийн тоног төхөөрөмжийг сонгоно.

2.2.2. сургалтын байгууллага нь шаардлагатай тоног төхөөрөмжийн хэрэгцээний судалгааг сургалтын байгууллагын түвшинд гаргах;

2.2.3. төсвийн ерөнхийлөн захирагч эсхүл түүний эрх олгосноор төсвийн төвлөрүүлэн захирагч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

а/ боловсролын систем дэх сургалтын хэрэглэгдэхүүний өнөөгийн төлөв байдлын судалгаа болон бусад нэмэлт судалгааны үр дүнг харгалзан шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн тодорхойлолтыг боловсруулж, батлах;

б/ төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургуулиудад тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй байдлын тоон болон чанарын үзүүлэлт,

хүртээмжийн шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үнэлгээ хийсний үндсэн дээр хамрагдах сургуулиудыг тогтоох;

в/ салбарын хэмжээнд тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын хүрээнд сургалтын тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах;

2.2.4.энэ аргачлалын 2.2.3-ын б/-д заасны дагуу тогтоосон сургалтын байгууллага нь тухайн сургалтын байгууллагад хуваарилагдах тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлаар 2.2.3-ын а/-д тодорхойлсон нэр төрлийн тоног төхөөрөмжөөс тухайн сургуулийн өнөөгийн нөхцөл байдал, онцлог хэрэгцээг харгалзан шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах хэрэгцээг эрэмбэлж, үе шаттай шийдвэрлэх төлөвлөгөө баталж, шийдвэрлэх;

2.2.5.сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага нь энэ аргачлалын 2.2.4-д тодорхойлсон санал, шийдвэрийн төслийг өөрийн удирдлага буюу эцэг, эхийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тус зөвлөлийн санал, дүгнэлтээр дэмжигдсэн жагсаалтыг баталснаар худалдан авах ажиллагааг явуулах;

2.2.6. Сургууль, цэцэрлэг нь Ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгч байгууллагаас холбогдох журмын дагуу худалдан авах ажиллагааг бие даан зохион байгуулна.

2.2.7.сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын үйл ажиллагааг сургалтын байгууллагын өөрийн удирдлага, багш ажилтны оролцоог хангаж, ил тод зохион байгуулж, тайлагнах.

2.2.8. Худалдан авах ажиллагаа зохион байгуулахтай холбоотой хүний нөөцийг мэргэжлийн байгууллагын сургалтад хамруулж бэлтгэл ажлыг хангасан байна.

ГУРАВ. САНХҮҮЖИЛТ

3.1 Журмын 2.2.5-д заасан шаардлагын дагуу гэрээ байгуулагдсан тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг нэгж байгууллагын “багаж хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж” зориулалтын “Бараа үйлчилгээний бусад зардал” (210901) эдийн засгийн ангилалд төлөвлөн хуваарилж, санхүүжүүлнэ.

ДӨРӨВ. ТАЙЛАГНАЛ

4.1 Сургууль, цэцэрлэг нь худалдан авсан тоног төхөөрөмжийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль, дүрэм, журмын дагуу бүртгэж, журмын дагуу эд хөрөнгийн тооллого хийж, өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн тайлагнана.

4.2 Сургууль, цэцэрлэг нь хөрөнгийн өөрчлөлтийг тухай бүр Боловсролын мэдээллийн нэгдсэн санд оруулна.

4.3 Энэхүү журмын 4.1-т заасны дагуу сургууль, цэцэрлэг нь тайлагнаагүй тохиолдолд 2.2.3 дах хэсгийн тоног төхөөрөмжийн нөхөн хангалтад хамрагдах сургалтын байгууллагын жагсаалтад хамруулахгүй байх үндэслэл болно.